



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Үр хөндөлтийг зохицуулах
журмыг батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 32.3 дугаар заалт, “Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ” MNS 5488:2005 Монгол улсын стандартыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Үр хөндөлтийг зохицуулах журмыг хавсралтаар баталсугай.
2. Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээний стандартын дагуу орчин нөхцлийг бүрдүүлэх, журмыг чанд баримтлан мөрдөн ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, амаржих газрын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Үр хөндөлтийн хор уршиг, ялангуяа аюултай үр хөндөлтөөс сэргийлэх талаар олон нийтэд сурталчлах ажлыг эрчимтэй зохион байгуулах, гарын авлага, зурагт хуудас боловсруулах, мэдээлэл, сургалт сурталчилгааны арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Ө.Ганчимэг), Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
4. Үр хөндөлтийн бүртгэл мэдээллийг чанаржуулах, аюултай үр хөндөлтийн тохиолдлыг бүртгэн улирал бүрийн эхний сарын 05-ны дотор Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн хэлтэст албан бичгээр ирүүлэх, сарын мэдээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Тогтолцооны судалгаа, статистикийн хэлтэст мэдээлж байхыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
5. Эрүүл мэндийн тухай хуулийн 32.1.1, 32.1.2 дахь заалт, Монгол улсын “Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ” MNS 5488:2005 стандарт, энэхүү журмыг зөрчсөн нь нотлогдсон тохиолдолд эмнэлгийн мэргэжилтний “Эмчлэх, сувилах, эм барих” зөвшөөрлийг хүчингүй болгохыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд, эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга нарт тус тус даалгасугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга А.Эрдэнэтуяад даалгасугай.
7. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 105 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н.УДВАЛ

080474

187
Эрүүл мэндийн сайдын
2014 оны 05 сарын 05 өдрийн
148 дугаар тушаалын хавсралт

ҮР ХӨНДӨЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

1. Эрүүл мэндийн тухай хуулийн 32.1, 32.2 дугаар заалт, "Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ" MNS 5488:2005 Монгол улсын стандартыг хэрэгжүүлэн, үр хөндөлттэй холбоотой асуудлыг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Үр хөндөлтийг эрт үеийн, хожуу үеийн гэж тодорхойлно.

- a. "Эрт үеийн үр хөндөлт" гэж жирэмсний эхний 12 долоо хоног дотор үр хөврөлийг авах ажилбарыг хэлнэ,
- b. "Хожуу үеийн үр хөндөлт" гэж жирэмсний 13 долоо хоногоос 22 долоо хоногийн дотор жирэмсэлтийг эмнэлгийн аргаар таслах ажилбарыг хэлнэ.

3. Эрт үеийн үр хөндөлтийг эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөл бүрдсэн, гарч болох хүндрэлээс сэргийлэх, эмчлэх бэлтгэлийг бүрэн хангасан, хүндрэл гарсан тохиолдолд арга зүйн дагуу найдвартай эмчлэх, 24 цагаар үйлчилгээ үзүүлэх, "Эх барих буюу эмэгтэйчүүдийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах" тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эмнэлэгт хийнэ.

4. Эрт үеийн үр хөндөлтийг эмэгтэйн өөрийнх нь хүсэлтээр төлбөртэйгээр, эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр төлбөргүйгээр холбогдох шинжилгээг бүрдүүлж, зөвхөн эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмч гүйцэтгэнэ.

5. Хожуу үеийн үр хөндөлтийг мэргэжлийн эмч нарын дүгнэлт, зөвлөгөөний шийдвэрээр дор дурьдсан заалтаар зөвхөн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, амаржих газар, нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт туршлагатай, мэргэжлийн зэрэгтэй эх барих, эмэгтэйчүүдийн эмч гүйцэтгэнэ.

- a. Тухайн жирэмсэлт нь эх, ургийн амь нас, эрүүл мэндэд аюултай болох нь тогтоогдсон,
- b. 18 хүртэлх насны охид өөрөө хүсвэл эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлөөр,
- c. 40-өөс дээш насны эмэгтэй өөрөө хүсвэл,
- d. Сэтгэцийн эмгэгтэй,
- e. Цусан төрөл ойртсон нь нотлогдсон,
- f. Бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэлсэн.

6. Дээр дурьдсан заалтуудаас бусад тохиолдолд жирэмснийг хожуу хугацаанд таслахыг хориглоно.

7. Дараах тохиолдолд үр хөндөхийг түр хойшлуулж, холбогдох эмчилгээг хийсний дараа үр хөндөх ажилбарыг гүйцэтгэнэ.

- a. Эрхтэн тогтолцооны цочмог үрэвсэл болон үрэвсэлт өвчний сэдрэлттэй,
- b. Бэлэг эрхтний хурц үрэвсэлтэй болох нь нотлогдсон,

8. Үр хөндөх ажилбар хийсэн эмч тухайн ажилбарын талаар "Үр хөндөлт"-ийн түүхэнд тэмдэглэж, үр хөндөлтийн бүртгэлийн маягтанд бүртгэнэ.

9. Эрт үеийн үр хөндөлтийг хийхийн өмнө эмэгтэйд үр хөндөлтийн талаар таниулж, сонгосон аргаар үр хөндүүлэх зөвшөөрлийг бичгээр авч, "Үр хөндөлт"-ийн түүхэнд хавсаргана.

10. Хожуу үед үр хөндөхөд дараах баримт бичгийг бүрдүүлж, "Үр хөндөлт"-ийн түүхэнд хавсаргана.

- a. Эмч нарын зөвлөгөөний шийдвэр,
- b. Үр хөндүүлэх хүсэлтийг эмэгтэй өөрөө, 18 хүртэлх насны охидын эцэг, эх, асран хамгаалагч бичгээр гаргана,
- c. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухай хуулийн байгууллагын тодорхойлолт,
- d. Цусан төрөл ойртсон нь нотлогдсон хуулийн байгууллагын тодорхойлолт.

11. Үр хөндөлтийн дараа гарч болох хүндрэл, жирэмслэхээс сэргийлэх үр дүнтэй аргын талаар зөвлөгөөг үйлчлүүлэгчид өгч, энэ тухай "Үр хөндөлт"-ийн түүхэнд тэмдэглэнэ.

12. Эрүүл мэндийн статистик мэдээлэл хариуцсан эмч үр хөндөлтийн тухай тайланг ЭМТ 201.11 маягыг үндэслэн нэгтгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Тогтолцооны судалгаа, статистикийн хэлтэст мэдээлнэ.